



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ
ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ

2021 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

“Оюу толгой” ордын ашиглалтын тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын 2021 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/01 захирамжаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн орон тооны бус шинжээч 10 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилж, Оюутолгой ордыг ашиглах тухай Монгол Улсын Засгийн газар болон “Айвенхоу майнз монголия инк” ХХК, “Айвенхоу майнз лимитед”, “Рио тинто интернэшнл холдингс лимитед” компани хооронд байгуулсан “Хөрөнгө оруулалтын гэрээ”, “Хувь нийлүүлэгчдийн гэрээ”, “Нэмэлт өөрчлөлт оруулж, дахин тодотгосон Хувь нийлүүлэгчдийн гэрээ”, болон “Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө” нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцсэн эсэх, Монгол Улсад ашигтай гэрээ мөн эсэх талаар шинжилгээ, судалгаа хийн мэргэжлийн дүгнэлт гаргах үүрэг өгсөн.

Ажлын хэсэг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс гаргаж өгсөн дараах баримт бичгүүдийн хүрээнд судалгаа хийв. Үүнд:

1. Монгол Улсын Их Хурлын “Үндсэн зарчим, удирдамж батлах тухай” 2008 оны 40 дугаар тогтоол болон түүний “Оюу толгойн зэс-алтны ордыг хамтарч ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үндсэн зарчим, удирдамж” гэсэн 2 дугаар хавсралт,
2. “Оюу толгойн ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай” УИХ-ын 2009 оны 57 дугаар тогтоол, “Хуулийн төсөл буцаах тухай” 2009 оны 58 дугаар тогтоол,
3. “Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” УИХ-ын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 92 дугаар тогтоол,
4. 2015 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн “Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”,
5. Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн “Оюу толгойн ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай хуулийн төсөл, зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Оюутолгойн ордыг ашиглах талаар Монгол Улсын Засгийн газар болон “Айвенхоу майнз монголия инк” ХХК-ийн хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний тухай” хэлэлцсэн хуралдааны 13 дугаар тэмдэглэл,

6. Оюутолгойн ордыг ашиглах тухай Монгол Улсын Засгийн газар болон “Айвенхоу майнз монголия инк” ХХК, “Айвенхоу майнз лимитед”, “Рио тинто интернэшнл холдингс лимитед” компани хооронд 2009 оны 10 дугаар сарын 6-ны өдөр байгуулсан “Хөрөнгө оруулалтын гэрээ”,

7. “Эрдэнэс Монгол” ХХК болон “Айвенхоу Оюу Толгой” (Ви Ви Ай) Лтд, “Оюу Толгой Нидерланд Би Ви”, “Оюу Толгой” ХХК-ийн хооронд 2011 оны 6 дугаар сарын 8-ний өдөр байгуулсан “Хувь нийлүүлэгчдийн гэрээ”.

8. 2011 онд байгуулсан “Нэмэлт өөрчлөлт оруулж дахин тодотгосон Хувь нийлүүлэгчдийн гэрээ”,

9. Монгол Улсын Их Хурлын чуулганы 2015 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны “Оюу толгойн асуудлаарх Ерөнхий сайдын мэдээлэл”-ийн талаарх 16 тоот тэмдэглэл,

10. Улсын Их Хурлын даргын 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 57 дугаар захирамжаар байгуулсан Оюу Толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг шалгаж, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийн 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн танилцуулга.

Гэрээ байгуулах бэлтгэл үеийн болон Оюу толгой ордын ашиглалтын явцтай холбоотой асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр авч хэлэлцэж, гаргасан зөвлөмжийн баримт бичгүүдтэй танилцах хүсэлт тавьсан боловч нууцын учир шалтгаанаас танилцах боломж олдсонгүй. Түүнчлэн бидэнд УИХ-ын Ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй адил мэргэжлийн өргөн бүрэлдэхүүнийг оролцуулан шинжилгээ хийх боломж байгаагүй тул тэдний гаргасан санал, дүгнэлтээс шинжээчдийн үндэслэл, байр суурьтай тохирч буй хэсгийг тодорхой хэмжээгээр баримт, нотолгоо болгон ашигласан.

Зөвлөлийн шинжээчид бид нэгд, *Оюу толгойн гэрээнүүд болон төлөвлөгөө нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцсэн эсэх талаарх шинжилгээг* “Хөрөнгө оруулалтын гэрээ”-ний агуулгын хувьд 1994 оны үзэл баримтлалын зарчим байр суурьтай харьцуулан, харин 2009 оны “Хувь нийлүүлэгчдийн гэрээ”, 2011 оны “Нэмэлт өөрчлөлт оруулан дахин тодотгосон хувь нийлүүлэгчдийн гэрээ” болон “Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-ний агуулгын хувьд 2010 оны үзэл баримтлалын зарчим, заалтуудтай харьцуулан гүйцэтгэлээ, хоёрт, *Оюу толгойн гэрээнүүд болон төлөвлөгөө нь Монгол Улсад ашигтай гэрээ мөн эсэхийн тухайд шинжилгээг* гэрээний заалтуудыг УИХ-ын ажлын хэсгийн гаргасан дүгнэлт болон зарим баримтуудтай харьцуулан эдийн засгийн үр өгөөж талаас нь гүйцэтгэж, үнэлгээ өглөө, гуравт, *Үнэлгээний үр дүн дээрээ тулгуурлан Оюу толгойн ордын ашиглалтыг Монголын талд үр өгөөжтэй болгохын тулд цаашид үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хэрэгжилт талаас нь анхаарах зарим боломжийг тодорхойллоо.*

Ажлын хэсэгт орсон бүрэлдэхүүнээс шинжээч С.Болд, Ч.Сайнсанаа, Д.Золжаргал нар ашиг сонирхлын зөрчилтөйд тооцогдож магадгүй гэсэн үндэслэлээр, Ч.Баатар, П.Баярсайхан нар биеийн эрүүл мэндийн шалтгаанаас шинжээчийн дүгнэлт гаргах ажилд оролцоогүй болно.

Нэг. Оюу толгойн гэрээнүүд болон төлөвлөгөө нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцсэн эсэх талаар:

А. Оюу толгойн ордыг ашиглах тухай “хөрөнгө оруулалтын гэрээ”-ний хувьд:

1.1. Оюу толгой ордыг ашиглах “Хөрөнгө оруулалтын гэрээ” нь Монгол Улсын 1994 оны үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын дараах заалтууд руу чиглэсэн алхам хийхийг оролдсон гэж үзэж болох юм. Үүнд:

- “Стратегийн ач холбогдолтой салбаруудыг хөгжүүлэх” чиглэлээр гадаадын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих” заалтын хүрээнд зах зээлийн үеийн гадаадын хөрөнгө оруулалт татсан стратегийн ач холбогдол бүхий том төслийг эхлүүлэх анхны алхам хийсэн.
- “Дэлхийн улс орнуудтай худалдаа-эдийн засгийн харилцаа хөгжүүлэхдээ эдийн засагт, нэн ялангуяа стратегийн ач холбогдолтой салбарт нэг буюу хэсэг орны ноёрхол тогтох, хараат байдалд орох, түүхий эдийн хавсарга болохоос сэргийлэх. Манай улстай чөлөөтэй харилцах сонирхлыг өндөр хөгжилтэй нөлөө бүхий улс орнуудад бий болгох” заалтын хүрээнд үндэстэн дамнасан том корпорацуудтай түншлэх оролдлого хийсэн.

1.2. “Оюу толгой ордыг ашиглах “Хөрөнгө оруулалтын гэрээ”-ний боловсруулалт, батлах үйл явц нь Монгол Улсын 1994 оны үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын дараах заалтуудын боломжийг ашиглаж чадаагүй байна. Тухайлбал:

- Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын “Гадаад орны хөрөнгө оруулагчдад үзүүлэх аливаа хөнгөлөлт, тэдний эдийн засгийн сонирхлыг хамгаалах арга хэмжээг монголын үндэсний үйлдвэрлэгчид, хөрөнгө оруулагчдад үзүүлдэг хөнгөлөлт, эдийн засгийн нөхцөлөөс давуутай болохоос сэргийлж, хяналт тавих” заалтын хувьд: 1/ УИХ-ын 2009 оны 57 дугаар тогтоолоор Засгийн газарт чиглэл болгосон үүрэг гэрээнд зөрчигдсөн, 2/ Монгол Улсын Үндсэн хууль болон Олон улсын гэрээний тухай хуулийн олон улсын гэрээг соёрхон батлах тухай заалт зөрчигдсэн тул “Олон улсын гэрээ” гэж үзэх үндэслэлгүй байна. *(Хавсралтын дугаар 1-д үндэслэлд холбогдох баримтыг хавсаргав)*
- Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын “Үндэсний аюулгүй байдлыг хангах үндсэн арга хэрэгсэл нь баттай мэдээлэл, нарийн судалгаа, тооцооны үндсэн дээр үйл явдлын өрнөлт, хөгжлийг урьдаас харж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах явдал мөн” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй.

Үндэслэл: 1/ дэлхийн эдийн засаг хямарсан үед урьд өмнө ийм том хөрөнгө оруулагч талтай хамтран ажилласан туршлагагүй, олон улсын хэмжээнд үнэлэгдэх мэргэжилтэн бэлтгэгдээгүй нөхцөлд УИХ-ын 2008 оны 40 дугаар тогтоолоор хоёр сар хүрэхгүй хугацаанд гэрээг боловсруулж төслийг өргөн мэдүүлэх үүрэг өгсөн нь баттай мэдээлэл, нарийн судалгаа, тооцоон дээр үндэслэх боломжийг хязгаарласан байх магадлал өндөр байна, 2/ нэгдсэн

тооцоо судалгаа, байр суурь байхгүй байсныг Засгийн газрын тэргүүнүүдийн Оюу толгойн үр өгөөжийн талаарх төсөөлөл өөр өөр байснаас харагдаж байна. *(Хавсралтын дугаар 2-т үндэслэлд холбогдох баримтыг үзүүлэв)*

- “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл тухайн үеийн байдлыг харгалзан энэхүү үзэл баримтлалыг хэрэгжүүлэх стратеги, тактикийг уялдуулан зохицуулах үүргийг хүлээх бөгөөд үндэсний аюулгүй байдал хэрхэн хангагдаж байгаад хяналт тавьж, Улсын Их Хуралд жил бүр мэдээлж байна” гэсэн заалт хэрэгжээгүй байна. Үндэслэл нь гэрээ байгуулагдах үеийн болон шинэ үзэл баримтлал гарах хүртэлх холбогдох бүх баримт бичгүүдэд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг дагаж мөрдсөн талаарх мэдээлэл байхгүй байна, энэ нь стратегийн ач холбогдол бүхий энэ гэрээ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн анхаарлын гадна байсныг илтгэж байна.

Энэ нь гэрээ, төлөвлөгөөг үндэсний аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс сайжруулах ямар боломжийг алдагдуулсан байж болох талаарх үндэслэлийн гаргалгааг хавсралтын дугаар 3-т орууллаа.

Б. 2009 оны “Хувь нийлүүлэгчдийн гэрээ”, 2011 оны “Нэмэлт өөрчлөлт оруулан дахин тодотгосон хувь нийлүүлэгчдийн гэрээ” болон “Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-ний хувьд:

1.3. Оюу толгой ордыг ашиглах “Хөрөнгө оруулалтын гэрээ”-г байгуулах үеийн үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын холбогдох заалтуудыг харгалзан үзээгүйгээс алдсан боломжууд дараагийн гэрээнүүд болон далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөөг боловсруулах, батлах явцад мөн адил давтагдсан байна. Эдгээрийн үндэслэлийг 2010 оны үзэл баримтлал болон дүгнэлтийн баримтуудаас харж болно.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын “Аюулгүй байдалд хандах хандлага, түүнийг хангах үйл ажиллагаа нь мэдлэг, мэдээлэл, дүн шинжилгээнд суурилна” гэсэн “Мэдлэгт суурилах” болон “Болзошгүй аюул, сорилтыг бодитой тодорхойлж, тэдгээрийг гэтлэн давахад хязгаарлагдмал нөөц боломжийг үр дүнтэй дайчилна” гэсэн “Бодитой хандах” зэрэг үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчмуудыг мөрдсөн бол “Хувь нийлүүлэгчдийн гэрээ”, “Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө” болон “нэмэлт өөрчлөлт оруулан дахин тодотгосон хувь нийлүүлэгчдийн гэрээ” (НӨОДТХНГ)-нд хавсралтын дугаар 4-т баримтаар оруулсан зөрчлүүдээс сэргийлэх боломж байсан.

Өнөөдрийг хүртэл “Оюу Толгой” төслийн хөрөнгө оруулагч талыг бүрэн судлаагүй гэж үзэж болно. Гэрээ байгуулагч гадаадын хамтрагч талын компаниудын бүтэц, шуудангийн компаниудыг судалж, дүгнэлт гаргасан ямар нэгэн баримт бичиг байхгүй байгаагаас харагдаж байна.

1.4. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын “Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагууд, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд нь энэхүү үзэл баримтлалын үзэл санааг Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомж болон эрх зүйн бусад холбогдох шийдвэрээр

бэхжүүлж, тус тусын эрх хэмжээний дотор хэрэгжүүлэх үүрэгтэй” гэсэн заалтыг баримтлаагүй нь Оюу толгой ордын ашиглалттай холбоотой гэрээ, төлөвлөгөө, ТЭЗҮ-г үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын үзэл санаатай уялдуулан боловсруулах, хэрэгжүүлэх боломжийг ашиглаж чадаагүй гэж үзэх үндэстэй. (Үндэслэлд холбогдох баримтыг хавсралтын дугаар 5-д орууллаа)

1.5. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын “Үндэсний аюулгүй байдлын зөвлөл Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, холбогдох хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн биелэлтэд байнгын хяналт тавьж, үндэсний аюулгүй байдлын нөхцөл байдалд үнэлгээ өгнө” гэсэн Үндэсний аюулгүй үзэл баримтлалыг хэрэгжүүлэх, хяналт тавих тогтолцооны заалт хэрэгжихгүй байсан нь нэгд, Оюу толгой ордын ашиглалтыг Үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлаас ангид байлгах, хоёрт, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын үндэсний ашиг сонирхлыг илэрхийлсэн чухал заалтуудын хэрэгжилтийг “Оюу толгой” ордын ашиглалтын гэрээ, далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөөний боловсруулалт, хэрэгжилтэд анхаарахгүй байх, гуравт, олон зөрчил дагуулсан НӨОДТХНГ байгуулагдах нөхцөлийг тус тус бүрдүүлсэн байх магадлал өндөр байна.

Оюу толгойн гэрээнүүд болон төлөвлөгөө нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцсэн эсэх талаар дүгнэхэд: Нэгдүгээрт, “Оюу толгой” ордыг ашиглах асуудлыг эхлүүлсэн нь стратегийн ач холбогдол бүхий орд газрыг эргэлтэд оруулах оролдлого мөн боловч түүний гэрээ, төлөвлөгөөний боловсруулалт, хэрэгжилт, хяналтын механизм нь үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын зарчим, шаардлагатай нийцсэн гэж үзэхгүй байна, Хоёрдугаарт, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь үндэсний аюулгүй байдлын талаарх төрийн бодлогын нэгдмэл, залгамж чанарын үндэс болно” гэсэн заалтыг баримтлаагүй нь “Оюу толгой” ордын ашиглалтын асуудлыг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдуулж чадаагүйн суурь үндэс болж байна, гуравдугаарт, “Оюу толгой” ордын ашиглалтын асуудлыг үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын зарчим, шаардлагад нийцүүлэн авч үзэхгүй байгаа нь уг ордыг Монгол Улсад ашигтай байх боломжийг бууруулж байна.

Хоёр. “Оюу толгой” ордыг ашиглах “Хөрөнгө оруулалтын гэрээ” Монгол Улсад ашигтай гэрээ мөн эсэхийн тухайд:

2.1. Хэдийгээр Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын чухал зарчим, шаардлагуудтай уялдаагүй боловч УИХ-ын 2008 оны 40 дугаар тогтоолоор баталсан “Оюу толгойн зэс-алтны ордыг хамтарч ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үндсэн зарчим, удирдамж” болон 2009 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Оюу толгойн ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай” заалтууд нь Оюу толгой ордыг ашиглах тухай “Хөрөнгө оруулалтын гэрээ”-г Монгол Улсад ашигтай гэрээ байлгах эрх зүйн үндсийг тодорхойлж өгсөн байна. Харин УИХ-ын 57 дугаар тогтоолоор “Хөрөнгө оруулалтын гэрээ” байгуулахыг Засгийн газарт зөвшөөрсөн нь түүний “Олон улсын гэрээ”-ний статусыг алдагдуулахад хүргэсэн байна. (Үндэслэлийг хавсралтын дугаар 1-ээс үзнэ үү)

2.2. “Хөрөнгө оруулалтын гэрээ”-нд УИХ-ын 2008 оны 57 дугаар тогтоолын “Эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар анхны хөрөнгө оруулалтыг нөхсөний дараа төрийн эзэмшлийн хувьцааны хэмжээг 50-иас доошгүй хувьд хүргэж нэмэгдүүлэх асуудлыг хөрөнгө оруулагчтай тохиролцон шийдвэрлэхийг Засгийн газарт үүрэг болгосныг зөрчсөн нь Монгол Улсад төрийн эзэмшлийн хувьцааны хэмжээг 50-иас доошгүй хувь болгож нэмэгдүүлэх асуудлыг 2041 оноос өмнө шийдвэрлэх боломжгүй болгосон байна. Үндэслэлтэй холбогдох баримтыг хавсралтын дугаар 6-д орууллаа.

2.3. “Оюу Толгой” компанийн гүний уурхайн бүтээн байгуулалтын санхүүгийн тооцоолол Монгол Улс 2051 он хүртэл ногдол ашиг авахгүйгээр зогсохгүй 22 тэрбум ам.долларын өртэй болж болзошгүй магадлал байгааг харуулсан байна. Үндэслэлд холбогдох баримтыг хавсралтын дугаар 7-д орууллаа.

2.4. Гэрээнд оролцогч талуудын эрх тэгш, харилцан ашигтай байх тэнцвэр алдагдсан, хөрөнгө оруулагчтын дүнд тавих хяналт байхгүй байгаа, хөрөнгө оруулалтын хэмжээг жил бүр нарийн тохироогүйгээс тодорхой хугацааны дараа байнгын үл ойлголцох байдалд хүрч байна. Мөн төслийн төлөвлөгдсөн болон авсан зээлийг бүрэн ашиглаагүй байна. Үндэслэлд холбогдох баримтыг хавсралтын дугаар 8-д оруулав.

2.5. “Хөрөнгө оруулалтын гэрээ”, “Хувь нийлүүлэгчдийн гэрээ”, “Нэмэлт өөрчлөлт оруулан дахин тодотгосон хувь нийлүүлэгчдийн гэрээ”, “Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө” болон төслийн ТЭЗҮ нь Монгол Улсад дараах эрсдэлүүдийг бий болгох магадлал өндөр байна. Үүнд:

- Оюу Толгой төслийн гадаадын хувь нийлүүлэгч тал Зээлийн барьцаагаар дамжуулан орд газрыг олон улсын өрийн бирж дээр өндөр үнээр зараад Монголоос гарах магадлалтай. Монгол Улс зээлийн барьцаагаар дамжуулан асар том газар нутгаа алдах эрсдэлтэй байна. Монгол Улсын газар нутагт заналхийлэх явдал уул уурхайгаар дамжин нэвтрэх магадлал байна. Хавсралтын дугаар 9-д үндэслэлд холбогдох материалыг оруулав.
- “Оюу толгой” ХХК-д хуулиар ашигтай нөхцөл байдал үүсгэж говийн бүсийн гүний цэвэр усыг хяналтгүйгээр үлэмж их хэмжээгээр ашиглуулж байгаа нь гүний цэвэр усны нөөцийг багасгах, улмаар эдийн засгийн болон экологийн гамшигт хүргэх ноцтой асуудлыг дагуулж байна. Хавсралтын дугаар 10-д холбогдох зарим баримтыг хавсаргав.
- Дээрх эрсдэлүүд болон “Оюу толгой” ордын ашиглалттай холбоотой иргэдийг талцуулсан зөрүүтэй мэдээлэл, удирдлагын дээд түвшин дэх үл ойлголцол, намын талцал зэрэг нь нийгэм-улстөрийн том эрсдэлийг бий болгох талтай. Хавсралтын дугаар 11-д холбогдох зарим баримтыг хавсаргав.

Гурав. Оюу толгой ордын ашиглалтыг Монголын талд үр өгөөжтэй болгох зарим арга замын тухайд:

3.1. “Оюу толгой” ордын ашиглалтыг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцүүлэхийн тулд үзэл баримтлалын “Үндэсний аюулгүй байдлын

үзэл баримтлал, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль тогтоомж, төрийн бодлогын хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг улс орон даяар уялдуулан зохицуулах чиг үүргийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл хариуцна” гэсэн удирдлагын механизмыг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүний үр дүнд:

- Үндэсний аюулгүй байдлын зөвлөл “Оюу толгой” ордын ашиглалтын явц дахь үзэл баримтлал, холбогдох хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн биелэлтэд байнгын хяналт тавьж, хэрэгжилтийн нөхцөл байдалд нь үнэлгээ өгөх замаар субъектив эрсдэлийг бууруулах боломж бүрдэнэ.
- Төр үндэсний аюулгүй байдлыг хангах анхдагч үүргийнхээ хүрээнд “Оюу толгой” ордын ашиглалтын асуудлаар иргэдэд бодит мэдээлэл өгч, мэдлэгтэй байлгах, түүний үр өгөөжийг нэмэгдүүлэх үйл хэрэгт хувь нэмрээ оруулах боломжоор хангах замаар нийгэм-улс төрийн эрсдэлээс сэргийлэх боломж олгоно.

3.2. “Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” УИХ-ын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах замаар “Оюу толгой” ордын ашиглалтад гарч буй сөрөг үр дагавруудыг арилгахын тулд тогтоолыг хэрэгжүүлэх талаар Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцэж, үйл ажиллагааг эрчимжүүлэх хэрэгтэй юм.

3.3. Цаашид стратегийн ач холбогдолтой уул уурхайн ашиглалт болон бүтээн байгуулалтын ажлыг үндэсний язгуур ашиг сонирхолтой уялдуулан үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын үзэл санаатай нийцүүлэн хэрэгжүүлдэг жишгийг тогтоох нь зүйтэй байна.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН ШИНЖЭЭЧИД:




О.ҮРЖИН
(Шинжлэх ухааны доктор,
профессор, хошууч генерал)



Ш.БОЛДБААТАР
(Аюулгүй байдал судлалын доктор)



Д.ЧИМЭД-ЮНДЭН
(Аюулгүй байдал судлалын доктор,
профессор, хошууч генерал)



М.ГАНБОЛД
Хууль зүйн ухааны доктор,
хошууч генерал



А.БАТСАЙХАН
(Аюулгүй байдал судлалын доктор,
хурандаа)

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн
2021 оны 3 дугаар сарын 29-ны өдрийн
шинжээчийн 01 дугаар дүгнэлтийн
хавсралт

Дүгнэлтүүдийн үндэслэлийн холбогдох баримтууд

д/д	Эх сурвалж	Үндэслэл болгосон баримтууд
Оюу толгойн гэрээнүүд болон төлөвлөгөө нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцсэн эсэх талаар:		
<i>Оюу толгойн ордыг ашиглах тухай “хөрөнгө оруулалтын гэрээ”-ний хувьд:</i>		
1.	УИХ-ын Ажлын хэсгийн нэгдсэн дүгнэлтийн 1.1 ба 1.4 дэх заалт	<p>1/. УИХ-ын 2009 оны 57 дугаар тогтоолоор “Эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар анхны хөрөнгө оруулалтыг нөхсөний дараа төрийн эзэмшлийн хувьцааны хэмжээг 50-иас доошгүй хувьд хүргэж нэмэгдүүлэх асуудлыг хөрөнгө оруулагчтай тохиролцон шийдвэрлэх”-ийг Засгийн газарт үүрэг болгосон боловч Хөрөнгө оруулалтын гэрээнд уг асуудлыг гэрээний үндсэн хугацаа, түүний сунгалттай (хоёр удаа хорь, хорин жилээр сунгах) холбон тодорхойлж, гэрээ хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш 31 дэх жилээс буюу 2041 оноос уг асуудлыг хөндөж, 50 хувь болох эрх үүсэхээр тусгасан байна.</p> <p>2/. Хөрөнгө оруулалтын гэрээний хувьд байгуулсан талууд нь нэг талаас Монгол Улсын Засгийн газар, нөгөө талаас Канад Улсад бүртгэлтэй хуулийн этгээд, мөн ИБУИБНУ-д бүртгэлтэй хуулийн этгээд байх ба эдгээр нь Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.15 дахь заалтад "Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах, гадаад улстай дипломат харилцаа тогтоох, цуцлах", Олон улсын гэрээний тухай Венийн конвенцийн 1 дүгээр зүйлийн (а), мөн Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтад тус тус заасны дагуу гэрээ байгуулах этгээдэд хамаарахгүй тул тус баримт бичгийн зохицуулалтад хамаарах “Олон улсын гэрээ” гэж үзэхээргүй байна.</p>

<p>2.</p>	<p>1/. Оюу толгой ордыг ашиглах Хөрөнгө оруулалтын гэрээний төслийн тухай танилцуулга.</p> <p>2/. Үндэсний аюулгүй байдал-25 Онол – практикийн бага хурлын эмхэтгэл: т.75</p>	<p>1/: а/ Канадын хөрөнгө оруулалттай “Айвенхоу майнз монголия инк” компани Оюу толгой ордыг ашиглах гэрээ байгуулах хүсэлтээ хэд хэдэн удаа илэрхийлсэн. 2006 онд хүсэлтийг дахин ирүүлж, хэлэлцээ хийсний үр дүнд гэрээний төслийг 2007 оны 6 дугаар сард УИХ-д өргөн барьж байсан. Энэ үед дэлхийн эдийн засгийн өсөлт 5,2%, Оюу толгой зэсийн үндсэн зах зээл болох БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 13% орчим байсан. 2007 оны 6 сард хөрөнгө оруулалтын гэрээг Засгийн газраас өргөн барихад зэсийн үнэ 7540 ам.доллар байжээ. Харин 2008 оны 12 дугаар сард хэлэлцээг дахин эхлүүлэхэд эдийн засгийн зах зээлийн нөхцөл байдал огцом өөрчлөгдөж, дэлхийн хамарсан хямралт нөхцөл байдалтай байсан. ОУВС-гийн тооцоолж байгаагаар дэлхийн эдийн засгийн өсөлт огцом буурч 0,5%-тай байх, хятадын эдийн засаг 6,7%-иар өсөх гэсэн бол дэлхийн эдийн засаг 1,7%-иар буурч, хятадын эдийн засаг 1,8%-иар буурах болно гэсэн өөдрөг төсөөлөл бас байсан.</p> <p>б/ Төслийн үндсэн хөрөнгө оруулагч болох “Рио Тинто” компани 2007 оны 6 дугаар сард дэлхийн хоёрдахь том уул уурхайн компани байсан бол 2009 оны 2 дугаар сарын байдлаар 40 хүрэхгүй тэрбум ам.долларын үнэлгээтэй дэлхийн тавдахь том компани болтлоо ухарсан байсан. Түүний хувьцааны үнэ 2007 оны 6 дугаар сард 100 ам.доллар шүргэж, 2008 оны дундуур 150 ам.доллар давж байсан бол гэрээ байгуулах үед 50 ам.доллар орчим хэлбэлзэж байжээ.</p> <p>Ийм нөхцөл байдалд хугацаа шахуу, дөнгөж сонгуулийн дараа шинэ бэлтгэгдээгүй бүрэлдэхүүн хэлэлцээ хийсэн нь тооцоо судалгаа муутай, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын шаардлага хангаагүй гэрээ байгуулагдахад хүргэсэн.</p> <p>2/. Оюу толгойн ордыг ашигласан цэвэр орлогоос Монголд үлдэх хувь: 2009 оны 5 сард Ерөнхий сайд С.Баярын төсөөлөл – 76%, 2009 оны 7 сард Ерөнхий сайд С.Батболдын төсөөлөл – 59%, 2012 оны 8 сард Ерөнхий сайд Н.Алтанхуягийн төсөөлөл – 71% байсан ба бодит байдал Ерөнхий сайд асан Д.Бямбасүрэнгийнхээр 17% байсан зэргээс дүгнэхэд үндэсний эрх ашгийг хамгаалах эрх зүй, зохион байгуулалтын бэлтгэлгүйгээр үндэстэн дамнасан корпорацуудтай тооцоо үндэслэлгүй түншилснийг</p>
-----------	---	--

		харуулж байна.
3.	<p>Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 1994 он. 7 дахь заалт</p> <p>Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 5.1 дэх заалт</p>	<p>“Үндэсний аюулгүй байдлыг хангах, бэхжүүлэх бодлого нь аливаа аюулыг “болзошгүй” үед нь тодруулан тогтоож арилгах, субъектив аюулыг цаг тухайд нь арилгах замаар объектив аюулыг багасгах, урьдчилан сэргийлэхэд чиглэнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлэх үйл явцыг эрчимжүүлж, хөрөнгө оруулалтын гэрээ боловсруулах, батлахад болон дараагийн гэрээ, төлөвлөгөө боловсруулалтын үед болзошгүй алдааг залруулан засах боломж байсан.</p> <p>“Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь үндэсний аюулгүй байдлын талаарх төрийн бодлогын нэгдмэл, залгамж чанарын үндэс болно” гэсэн заалтыг анхаарлын төвд авчирч, аливаа стратегийн ач холбогдол бүхий бүтээн байгуулалтад үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын шаардлага, үндэсний язгуур ашиг сонирхлын өнцгөөс хандах хандлагыг бий болгох боломж байсан.</p>
<p><i>“Хувь нийлүүлэгчдийн гэрээ”, “нэмэлт өөрчлөлт оруулан дахин тодотгосон хувь нийлүүлэгчдийн гэрээ” болон “Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-ний хувьд:</i></p>		
4.	<p>УИХ-ын ажлын хэсгийн нэгдсэн дүгнэлт:</p> <p>1.2, 1.3 болон 1.4 заалт</p>	<p>“Хувь нийлүүлэгчдийн гэрээ” буюу “Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон Хувь нийлүүлэгчдийн гэрээ”-ний хувьд талууд нь “Эрдэнэс МГЛ” ХХК болон “Айвенхоу Оюу Толгой” (Би Ви Ай) Лтд, “Оюу Толгой Нидерланд Би Ви”. “Айвенхоу Майнз Монголия Инк” ХХК (одоогийн “Оюу Толгой” ХХК) байх тул мөн Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулийн дагуу “Олон улсын гэрээ”-нд хамаарахгүй байна.</p> <p>Үүний нэгэн адил “Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө” болон “Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн нэмэлт төлөвлөгөө”-ний хувьд талууд нь “Эрдэнэс Оюу Толгой” ХХК болон “Туркойс Хилл Ресурсэс Лимитед”, “ТиЭйчАр Оюу Толгой” Лтд, “Оюу Толгой Нидерланд БиВи”, “Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед”, “Оюу Толгой” ХХК компаниуд байгаа нь мөн Монгол Улсын “Олон улсын гэрээ”-нд хамаарахгүй байна.</p> <p>НӨОДТХНГ-ний 16-д заасны дагуу Монголын талын эзэмшлийн 34 хувийн хувьцааг 50 хувь болгож нэмэгдүүлэх хэдий ч төслийн менежментийн одоо</p>

		<p>мөрдөж буй бүх эрх хөрөнгө оруулагч талд хэвээр хадгалагдаж, компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр Айвенхоугийн хувь нийлүүлэгчдийн саналаар бүрэн шийдвэрлэгдэж байхаар тусгажээ. Энэ нь Компанийн тухай хуулийн 34.6-д “Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх зарим асуудлаар энгийн хувьцаа эзэмшигчийн санал өгөх эрхийг энэ хуулиар хязгаарлаж болно” гэж, 63.5-д “Энэ хууль болон компанийн дүрэмд зааснаас дээгүүр хувь тогтоогоогүй, ... бол төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн гишүүдийг сонгохоос бусад асуудлаар гаргах шийдвэр хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болно.” гэж заасныг зөрчиж, зөвхөн Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид нь Компанийн ТУЗ-ийн бүх хурал болон Хувь нийлүүлэгчдийн бүх хуралд шийдвэрлэх саналын эрхтэй байхаар зохицуулсан байна.</p> <p>НӨОДТХНГ-ний 6.2 дахь заалтад нэг талаас Компани болон нөгөө талаас аль нэг Хувь нийлүүлэгч, эсхүл түүний Хамаарал бүхий компанийн хооронд хийгдэх аливаа хэлцэлд Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлгийн заалтыг хэрэглэхгүй байхаар заасан нь Компанийн тухай хуулийн 86.4-т “Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувь нийлүүлэгчийн тоо нь 10-аас илүүгүй бол компанийн дүрэмд энэ хуулийн 86.3-т зааснаас бусад тохиолдлыг зааж болно.” гэж заасантай нийцээгүй байна.</p>
5.	<p>УИХ-ын 2008 оны 40 дугаар тогтоол: 2 дугаар хавсралт.</p> <p>УИХ-ын даргын 2018 оны 57 дугаар захирамж</p>	<p>“Оюу толгойн зэс-алтны ордыг хамтарч ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах үндсэн зарчим, удирдамж”-д үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын үзэл санааг үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны “Төр, иргэний хамтын ажиллагаа”, “Мэдлэгт суурилах” , “Бодитой хандах” , “Даяаршлын хүчин зүйлийг харгалзах” зэрэг зарчмуудын агуулгыг тусгасан бол “Оюу толгой” ордын ашиглалтын гэрээ, төлөвлөгөөг боловсруулах, батлах, хэрэгжүүлэхэд үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах үүднээс хандах, мөн гэрээнүүд болон төлөвлөгөөг УИХ-аар соёрхон батлах боломж бүрдэх байсан.</p> <p>Оюу Толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг шалгаж, санал дүгнэлт гаргах</p>

		үүрэг бүхий ажлын хэсгийг томилсон нь “Хөрөнгө оруулалтын гэрээ” батлагдсанаас хойш 9 жилийн турш үл ойлголцох байдал үүсэж гүнзгийрсний дараа л УИХ-аас хяналт тавих үүргээ хэрэгжүүлэх анхны алхам болсон.
6.	Хөрөнгө оруулалтын гэрээ: 1.6 заалтыг 1.1 ба 15.11 заалтуудтай харьцуулсан дүгнэлт	УИХ-ын 2009 оны 57 дугаар тогтоолоор 'Эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар анхны хөрөнгө оруулалтыг нөхсөний дараа төрийн эзэмшлийн хувьцааны хэмжээг 50-иас доошгүй хувьд хүргэж нэмэгдүүлэх асуудлыг хөрөнгө оруулагчтай тохиролцон шийдвэрлэх*-ийг Засгийн газарт үүрэг болгосон боловч Хөрөнгө оруулалтын гэрээнд уг асуудлыг гэрээний үндсэн хугацаа, түүний сунгалттай (хоёр удаа 20 жилээр сунгах) холбон тодорхойлж, гэрээ хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш 31 дэх жилээс буюу 2041 оноос уг асуудлыг хөндөж, 50 хувь болгох талаар сонголт хийх эрхтэйгээр тусгасан байна.
7.	ЗГХЭГ-ын дэд дарга Б.Солонгын хэвлэлд өгсөн яриа https://news.zindaa.mn/3kap	“Оюу Толгой төслийн үнэ цэнийн 80 гаруй хувь нь газрын доор байдаг. Энэ утгаар нь харвал Монгол Улсын Засгийн газар “Оюу Толгой” компанийн гүний уурхайн бүтээн байгуулалтыг дэмжиж байгаа. Гэвч санхүүгийн тооцооллыг судлаад үзэхэд Монгол Улс 2051 он хүртэл ногдол ашиг авахгүйгээр зогсохгүй 22 тэрбум ам.долларын өртэй үлдэхээр байгааг гүний уурхайн ордын үйлдвэрлэлийн нөөцөд тулгуурлан гаргасан байсан”.
8.	УИХ-ын Ажлын хэсгийн нэгдсэн дүгнэлт: 2.3 болон 2.4	Хөрөнгө оруулалтын гэрээний дагуу Төсөлд оруулж байгаа хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн явц, хэмжээнд өнөөдрийг болтол Монголын нэг ч байгууллага хяналт тавиагүй, зөвхөн нөгөө тал бүх мэдээлэл, шийдвэрийг гаргаж байгаа нь гэрээнд оролцогч талууд эрх тэгш, тэнцвэртэй байх нөхцөлийг алдагдуулж байна. Олон Улсын банк, санхүүгийн байгууллагуудаас 4.3 тэрбум ам.долларын зээл авч ашигласнаас зээлийн цэвэр ашиглалт ойролцоогоор 4.1 тэрбум ам.доллар (зардал татварыг суутган тооцож, зээлдүүлэгчдээс шилжүүлсэн) болсон байна. “Рио Тинто”, “Түркоиз Хилл Ресурс” компанийн “Оюу толгой”-н далд уурхайн бүтээн байгуулалтын нэмэлт санхүүжилттэй холбоотой асуудлаар Арбитрын шүүх

		дээр маргаан үүсчээ.
9.	<p>УИХ-ын ажлын хэсгийн нэгдсэн дүгнэлт: Хоёрын 4</p> <p>Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр заалт</p>	<p>Оюу толгой компанийн барьцааны эд хөрөнгийн хувьд Монгол Улсын Засгийн газрын өмчлөлд байгаа 34 хувьд ногдох хувьцааг эс тооцвол бүхий л хөрөнгө, ирээдүйн мөнгөн урсгал орж ирэх данснуудыг барьцааны агент “Стандарт Чартеред Банк”-нд дамжуулан барьцаанд тавьжээ. Компанийн үндсэн болон үйл ажиллагааны бүхий л хөрөнгүүдийг барьцаанд тавьсан байна. Тухайлбал, хувьцаа, гадаад, дотоодын үйл ажиллагааны данс, Гэрээний эрхээ хүртэл Эрх шилжүүлэх гэрээгээр барьцаанд тавьжээ. Өөрөөр хэлбэл, ямар нэгэн эрсдэл үүсэхэд хөрөнгө оруулагч тал гэрээний эрхээ бусдад шилжүүлэх, эсхүл Оюу толгойн ордыг барьцааны хөрөнгөтэй нь худалдаад гарахыг үгүйсгэхээргүй болсон байна.</p> <p>Хуулийн заалтыг үндэслэн Засгийн газрын тогтоолоор Оюутолгой төслийг хэрэгжүүлэх зорилгоор Өмнөговь аймгийн Ханбогд, Баян-Овоо, Ханхонгор, Манлай, Цогтцэций сумдын нутагт авто зам, гүний усны шугам хоолой, харилцаа холбооны дэд бүтцийн барилга байгууламж болон цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих, 263730 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авч, хилийн заагийг тогтоосон боловч газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хадгалагддаг улсын тусгай хэрэгцээний газрын нэгдсэн мэдээллийн санд уг тогтоол нь Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5-д заасан “шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай” гэсэн зориулалтаар бүртгэгдсэн байгаа нь тухайн үеийн болон өнөөгийн эрх зүйн зохицуулалттай зөрчилдөж байна.</p>
10.	<p>Засгийн газрын 2011 оны 175 дугаар тогтоолд үндэслэсэн байдал</p>	<p>Засгийн газрын 2011 оны 175 дугаар тогтоолд үндэслэсэн нэрийн дор “Усны тухай” хуулийн 8 дугаар зүйлд “ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийг тогтоох “ эрх нь Улсын Их Хуралд хадгалагдахаар хуульчилсныг зөрчиж “Оюу толгой” ХХК-д ашигтай нөхцөл байдал үүсгэж говийн бүсэд гүний цэвэр усыг хяналтгүйгээр үлэмж их хэмжээгээр ашиглуулж байгаа нь гүний цэвэр усны нөөцийг багасгах, улмаар эдийн засгийн болон экологийн гамшигт хүргэх ноцтой асуудлыг дагуулж байна.</p>

11.	<p>“Өндөр түвшний авилга ба үндэсний аюулгүй байдал” сэдэвт социологийн судалгаа. МУИС, УБ., 2014</p> <p>2008 оны 7 дугаар сарын 1-ний үйл явц</p>	<p>Монголын улс төрчид, эрх мэдэлтэй хүмүүсийг гадаадын иргэд хахуульдаж, ашигт малтмалын том орд газрыг эзэмшин ашиглаж байна. Гадаадын иргэдэд зориуд ашигтай байлгахаар улс төрчид хууль гаргаж байна.</p> <p>Оюу толгой ордыг ашиглах “Хөрөнгө оруулалтын гэрээ”-г байгуулсан 4 сайдын 3 нь шүүхээс ял сонссон бол Дубайн гэх гэрээнд гарын үсэг зурсан төрийн өмчит компанийн 2 захирал мөн л буруутгагдаад байна.</p> <p>Сонгуулиас үүдэлтэй үймээн гарч 5 хүний амь нас үрэгдэж байсан гашуун сургамж манайд бий.</p>
-----	--	--

---oOo---